



МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
Цахим шуудан: info@mcud.gov.mn,
Цахим хуудас: www.mcud.gov.mn

2022.12.23 № 3/6061

танай _____-ны № _____-т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Барилга, хот байгуулалтын яамны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” /2022 он/-ний жилийн эцсийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт *2!* хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

СМ *С.МАГНАЙСҮРЭН*



152264073

**АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах									
1	1.1.	АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, төлө зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий болгомжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.					Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудасны нүүр хуудас (https://tsud.gov.mn/home) болон мэдээллийн самбарт АТГ-аас бэлтгэсэн tv шторк, инфографик, видео график, нийтлэл, төлө зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байршуулан, тогтмол шинэчлэн ажиллаж байна. Яамны цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдал цэсний авлигын эсрэг цэсэнд тус яамны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай баримт, АТГ-аас бэлтгэсэн tv шторк, инфографик, видео график, нийтлэл, төлө зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байршуулан, нийтэд хүргэж ажилласан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/168 дугаар тушаалаар "Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим хуудсыг хөтлөх журам", Нээлттэй мэдээллийг бэлтгэж, цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, түүнд хяналт тавих чиг үүргийн хуваарийг тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		100 хувь
2	1.2.	АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт					Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/101 дүгээр тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ахлуулан газар, хэлтсийн дарга, ахлах шинжээч, шинжээчдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан эрхэлсэн асуудал, салбарын хүрээнд хүнд суртал, авлигын индексийг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ төлөвлөж, баталсан төлөвлөгөө /2020-2024 он /-ний дагуу ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгээс харьяа агентлаг, байгууллагууд, төслийн		100 хувь

								Тохируулан зохион байгуулах.

нэгжийн удирдлагуудтай цахим уулзалтыг сар тутам зохион байгуулж ажиллаж байна. Үүнд:

Ажлын хэсгийн анхны хурлыг гишүүд болон харьяа байгууллага, төслийн нэгжийн удирдлагын хамт 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хийж Ажлын хэсгийн ахлагч Д.Баярсайхан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулсан. Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр, "Барилгын хөгжлийн төв" ТӨАДТҮГ-ын мэдээллийг 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр, "Төрийн орон сууцны корпорац" ХХК-ийн мэдээллийг 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2022 оны авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг 10 дугаар сарын 10-ны өдөр, Ажлын хэсгийн хуралдаанаар тус тус сонсож, мөн цаашид албан хаагчдыг авлигын эрсдэлд өртөхөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх, мөн салбарын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгож, авлигад өртөх өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа тусгай зөвшөөрөл олгох-ны цахим шилжилтийг үе шаттайгаар шуурхай зохион байгуулах зэрэг асуудлыг хөндөж, зарим үр дүнтэй ажиллаж байгаа төрийн байгууллагуудын сайн туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлэх зэргээр туршлага солилцох, мөн түүнчлэн Засгийн газраас болон холбогдох байгууллагуудаас ирүүлсэн үүрэг, чиглэлийг баримтлан сахилга бат, хариуцлагыг чанд сахиж ажиллахыг үүрэг болгох зэргээр үр дүнтэй ажиллаж байгаа болно. Тус төлөвлөгөөнд тусгагдсан салбарын үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулахад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Газар, хот байгуулалт, барилгын салбарын бүх төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрхтэй холбоотой үйл ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлж, цаг хугацаа, орон зайгаас үл хамаарсан иргэн төвтэй төрийн үйлчилгээг нэг цонхноос авах боломжийг бүрдүүлсэн ба шат дамжлага, хүнд суртал, авлигын индекс бууруулах боломжийг бүрдүүлсэн. Мөн "Газрын харилцаа-Цахим шилжилт" 1 сарын аяныг /10-р сард/ зарлаж, MGLRADIO-88.3 радио, Монгол коммент -TV9, Сошл PR-ын баг болон олны танил хүмүүстэй хамтран видео контент бэлтгэн egazart.gov.mn системийг сурталчилан хамтран ажилласан. 2021 оны 10-р сарын 1-нээс эхлэн иргэн, хуулийн этгээд захирамж нь гарсан газрын гэрчилгээ, кадастрын зургаа өөрөө үнэ төлбөргүй гэртээ хэвлэж авч, ашиглаж эхэлсэн. Энэ үйлчилгээ нэвтрээд "Газрын харилцаа-Цахим шилжилт" 1 сарын аяны хугацаанд 8742 иргэн хуулийн этгээд газрын гэрчилгээ, кадастрын зургаа хэвлэж авсан байна. Ингэж иргэн хуулийн этгээд үнэ төлбөргүй хэвлэж авснаар 214,030,000 төгрөг хэмнэжээ. Өөрөөр хэлбэл хэрэв газрын албан дээр очиж хэвлүүлж авсан бол энэ хэмжээний мөнгө төлөх байсан гэсэн үг. Тушаах мөнгөн дүн нь энэ

						Боловч иргэдийн цаг, хугацаа, эдийн засагт үүнээс их хэмнэлт үүсгэсэн үйлчилгээ юм.	
3	1.3. Авлигын эсрэг ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиглуулах.					Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудасны нүүр хуудас (https://tmsid.gov.tn/home)-т болон яамны Мэдээллийн самбарт Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд томдол мэдээлэл хүлээн авах утас 110”-ыг байршуулсан бөгөөд Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн тухай бүр ирүүлдэг мэдээллийг байршуулж, холбогдох мэдээлгүүдийг тогтмол шинэчлэн ажиглаж байна.	100 хувь
2	2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-т хүргүүлж, албан хаагчдаа холбогдох сургалтад хамруулсан байх.					Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т болон Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан “Авлигын эсрэг сургалт, даван сургалтыг зохион байгуулах” зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын албан хаагчдыг авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр, мөн түүнчлэн Барилга, хот байгуулалтын яамны Мэдээллийн цагаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Д.Золжаргал, С.Баярцэцэг нар “Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” сэдэвт сургалт, сурталчилгаа, мэдээллийг байгууллагын нийт албан хаагчдын дунд тус тус 2 удаа зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд давхардсан тоогоор 122 албан хаагч хамрагдсан.	100 хувь
4						Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т болон Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан “Авлигын эсрэг сургалт, даван сургалтыг зохион байгуулах” зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын албан хаагчдыг авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр, мөн түүнчлэн Барилга, хот байгуулалтын яамны Мэдээллийн цагаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Д.Золжаргал, С.Баярцэцэг нар “Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” сэдэвт сургалт, сурталчилгаа, мэдээллийг байгууллагын нийт албан хаагчдын дунд тус тус 2 удаа зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд давхардсан тоогоор 122 албан хаагч хамрагдсан.	100 хувь

	2.2.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байдал		<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах хадгалах журмыг хэрэгжүүлэн ажиллаж ямар нэгэн зөрчил дутагдал гаргаагүй бөгөөд сургалт мэдээллийг 2 удаа зохион байгуулсан болно.</p> <p>Авлигын эсрэг хуульд мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж өгөх үүрэгтэй гэж заасны дагуу яамны дотоод цахим системд https://msuid.able.mn/main.php?r=cNlvbGjI/ мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага болон яамны Эрх бүхий албан тушаалтны боловсруулсан ЗӨВЛӨМЖИЙГ байршуулсан. Мөн 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр шинээр төрийн албанд орсон /хуульд заасан үндэслэлээр түр орлон гүйцэтгэж байгаа зэрэг/ 5 албан хаагчдад ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн гаргах талаарх сургалтыг биечлэн зохион байгуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/101 дүгээр тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ахлуулсан газар, хэлтсийн дарга, ахлах шинжээч, шинжээчдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан эрхэлсэн асуудал, салбарын хүрээнд хүнд суртал, авлигын индексийг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ төлөвлөж, баталсан төлөвлөгөө /2020-2024 он/-ний дагуу ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгээс харьяа агентлаг, байгууллагууд, төслийн нэгжийн удирдлагуудтай цахим уулзалтыг сар тутам зохион байгуулж ажиллаж байна. Үнд:</p> <p>Ажлын хэсгийн анхны хурлыг гишүүд болон харьяа байгууллага, төслийн нэгжийн удирдлагын хамт 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хийж Ажлын хэсгийн ахлагч Д.Баярсайхан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулсан. Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр, "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын мэдээллийг 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр, "Төрийн орон сууцны корпораци" ХХК-ийн мэдээллийг 06 дугаар сарын 09-ний өдөр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр тус тус Ажлын хэсгийн хуралдаанаар сонсож, мөн цаашид албан хаагчдыг авлигын эрсдэлд өртөхөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх, мөн салбарын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгож, авлигад өртөх өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа /тусгай зөвшөөрөл олгох/-ны цахим шилжилтийг үе шаттайгаар шуурхай зохион байгуулах зэрэг асуудлыг хөндөж, зарим үр дүнтэй ажиллаж байгаа төрийн байгууллагуудын сайн туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлэх зэргээр туршлага солилцох, мөн түүнчлэн Засгийн газраас болон холбогдох</p>	100 хувь 1
5				

					байгууллагуудаас ирүүлсэн үүрэг, чиглэлийг баримтлан сахилга бат, хариуцлагыг чанд сахиж ажиллахыг үүрэг болгох зэргээр үр дүнтэй ажиллаж байгаа болно.	
3.	Авлигатай тэмцэх газраас гаргасан шийдвэрийг биелүүлэх					
	3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх.				Авлигатай тэмцэх газраас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02/13838 тоот албан бичгээр, 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/696 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийг татан оролцуулах, ил тод нээлтэй байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэсэн арга хэмжээнүүдийг авах талаар ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн АТГ-аас "Монголын Барилгын инженер холбоо" ТББ-тай хамтран барилгын салбарыг авлигаас ангид байлгах, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд инженерүүдийн ёс зүйг бэхжүүлэх, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай, ил тод, хүнд суртал чирэгдэлгүй хургах чиглэлээр "Барилгын салбар дахь авлигын эрсдэл ба инженерийн ёс зүй" сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга, Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж нар тус тус оролцож, барилгын тусгай зөвшөөрөл олгох үйл явцын хяналтыг сайжруулах, ил тод болгох, хүнд суртал чирэгдлийг багасгах, барилга эхлэхээс дуусах хүртэл үйл явцын чанарын асуудал, хяналтын тогтолцоог сайжруулах, чанарын шаардлага хангаагүй барилгыг хүлээн авахгүй байх, мөн түүнчлэн зураг төсөл, магадлал хийгдээгүй, тендер сонгон шалгаруулалтгүй, улсын төсвийн төсөлд зураг төсөлгүй ажлуудыг оруулж төсөв баталдаг болон холбогдох бусад асуудлуудыг хөндөж, амжилттай оролцсон. Энэ хэлэлцүүлгээс 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 1/16409 дугаар зөвлөмжийг Барилга, хот байгуулалтын сайдад ирүүлж, зөвлөмжийн мөрөөр шаардлагатай арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллаж эхлээд байна.	100 хувь
7	3.2. Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.				Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 06/5903 дугаар, 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 06/5128 дугаар "Нүүрсний экспортыг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн тогтоолын төсөлд санал авсан болон "Говийн зам" ХХК, "Энержи ресурс" ХХК-тай холбоотой хүсэлт, танилцуулгын талаар, 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 06/16574 дугаар "Суруга Монгол" ХХК-д тусгай зөвшөөрөл олгосон эсэхтэй холбоотой, 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 06/14077 дугаар "Баянбумбат констракшн" ХХК-ийн 2022 оны 190 дүгээр, 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 06/15668 дугаар, 2022 оны 12 дугаар сарын 15-ны	100 хувь

								<p>өдрийн 06/17148 дугаар "Лакилайф" ХХК-д барилгын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй холбоотой, мөн 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 06/16573 дугаар, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 06/17191 дүгээр, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 06/17191 дүгээр, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 06/10508 тоот албан бичгийн дагуу "Түмэн наст конкрейт" ХХК/5711673/-ийн 2015 оноос хойш Бетон зуурмагийн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл авсан эсэх талаарх, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 06/10508 дугаар "Түмэн наст конкрейт" ХХК /5711673/-ийн 2015 оноос хойш Бетон зуурмагийн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл авсан эсэх талаарх, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 06/14933 дугаар "Наран гурт" ХХК-ийн Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нутаг дэвсгэрт барьж байгаа 120 айлын орон сууцны барилгатай холбоотой мөрдөгчийн мэдэгдлүүдийг тус тус хүлээн авч танилцаж, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн, тогтоосон хугацаанд албан бичгээр тухай бүр хариу өгч ажигласан байна. Мөн түүнчлэн мөрдөгчийн мэдэгдэлд туссан арга хэмжээнүүдийг дараах байдлаар хэрэгжүүлж ажиглаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар "Эрхэлсэн асуудал салбарын хүрээнд хүнд суртал, авлигын индексийг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ахлуулан Ёс зүйн зөвлөлийн дарга болон ахлах шинжээч нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. 2. Эрхэлсэн асуудал салбарын хүрээнд хүнд суртал, авлигын индексийг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгээс "Хүнд суртал, авлигын индексийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г боловсруулан уг төлөвлөгөөнд дараах асуудлуудыг тусгасан: <ul style="list-style-type: none"> -Харьяа байгууллагуудад сахилга бат, хариуцлага нэмэгдүүлэх, хүнд суртал, авлига хээл хахуулийн эсрэг авах арга хэмжээ болон соён гэгээрүүлэх талаар албан бичгээр үүрэг чиглэл, мэдээлэл өгч байх тухай бүр; -Харьяа байгууллагуудтай авлига, хүнд суртал, хээл хахуульд өртөх өндөр эрсдэл бүхий үйл ажиллагаа, салбарын асуудлаар соён гэгээрүүлэх, мэдээлэл солилцох талаар цахим уулзалтуудыг улирал тутам хийх;
--	--	--	--	--	--	--	--	--

				<p>-Салбарын үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулахад хяналт тавьж, хэрэгжилтийг хангах;</p> <p>-Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захираганы болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг албан хаагчдад танилцуулах, мэдээлэл өгөх /Барилга, хот байгуулалтын яамны Ёс зүйн зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, дүрмийг батлуулсан бөгөөд харьяа байгууллагуудад Ёс зүйн зөвлөл байгуулж, дүрмийг батлуулж ажиллахыг үүрэг болгосон/;</p> <p>-Авлига, ашиг сонирхлын зөрчилд авлигийн эсрэг хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх, Авлигын эсрэг хууль зөрчсөн зөрчлийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн, шалгуулах, албан тушаалтан ажил, үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн авлигын шинжтэй үйлдлийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэх;</p> <p>-Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдаж, мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн тухай бүр нэмэлт, өөрчлөлтийг оруулж зөрчлийг арилгах; албан тушаалтан авлигын эрсдэлд өртөх, нөхцөл, болгомжийг бууруулах, удирдлагын зүгээс тавих хяналтыг сайжруулахад онцгой анхаарч ажиллах зэрэг зохион байгууллагын арга хэмжээнүүд.</p> <p>Цаашид Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд яам, газар, харьяа байгууллагууд хариуцан болон хамтран хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээнүүдийг тухай бүр зохион байгуулах, биелэлтийг хангаж, үр дүнг цахим хуудаст байршуулах, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх мөн түүнчлэн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, авлига, хээл хахууль, хүнд сурталтай тууштай тэмцэж, ажлын хариуцлага, дэг журмыг чангатгах чиглэлээр онцгой анхаарч ажиллахыг бүх шатны удирдлага, төрийн албан хаагчдад тухай бүр хатуу анхааруулж, ажиллагааг төлөвлөж байна.</p>	100 хувь
8	3.3.Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.				

					<p>ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, авлига, хээл хахуультай бүх шатанд тууштай тэмцэж, ажлын хариуцлага, дэг журмыг чангатгаж, иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг шуурхай шийдвэрлэн, дутагдал гаргасан удирдах, гүйцэтгэх албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллахад онцгой анхаарч ажиллахыг үүрэг чиглэл болгосон.</p>	
4.	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх</p>				<p>Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх үйл ажиллагааг дэмжиж, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 18, 21, 22, 23 дугаар тушаалуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгэх үйл ажиллагааг 3 жилийн хугацаатай гэрээний үндсэн дээр гүйцэтгэх үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг "Монгол барилгын үндэсний ассоциаци" ТББ болон түншлэгч 7 төрийн бус байгууллага, Барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг "Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ гүйцэтгэж байна. Барилгын салбарын ажигтныг даван сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг "Монголын барилгачдын нэгдсэн холбоо" ТББ болон түншлэгч 12 ТББ гүйцэтгэж байна.</p>	100 хувь
9	<p>4.1. Авлигын эсрэг төрийн болон бус төрийн хэвшил, байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах.</p>				<p>Мөн түүнчлэн бизнес, эдийн засаг, нийгмийн бүхий л төрлийн судалгааны бүтээгдэхүүн үйлчилгээг төрийн байгууллагад мэргэжлийн өндөр түвшинд чанартай хүргэх зорилго бүхий "SICA" компаниас Барилга, хот байгуулалтын яаманд хандаж "Шударга байдлын үнэлгээ" хийх зорилгоор судалгаа хийх хүсэлт ирүүлсэн. Уг судалгаа нь Монгол Улсад Авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг судалж, авлигын эсрэг бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээ мэдээлэл цуглуулах ач холбогдолтой. Энэ түүврийн судалгааг тус яамнаас Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Ц.Батчимэг "Эс ай си Эй" ХХК-ийн Мэдээлэл цуглуулалтын ахлах менежер Э.Нямдаваатай хамтран зохион байгуулсан бөгөөд тус яамны албан хаагчдаас нийт 50, тус яамаар үйлчлүүлдэг 30 аж ахуйн нэгж байгууллагыг тус тус хамруулсан мөн "Бодлогын шийдэл" ТББ, АТГ-тай Шударга байдлын үнэлгээний судалгааны мэдээлэл цуглуулах, тайлан бэлтгэж, үр дүнт олон нийтэд мэдээлэхээр ажиллаж байгаа бөгөөд тус байгууллагатай хамтран, үр дүнтэй ажиллаж байна.</p>	100 хувь
10	<p>4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас</p>				<p>Барилга, хот байгуулалтын яамнаас 2022 оны жилийн эцсийн байдлаар нээлттэй сонгон шалгаруулалтаар төндөр зарлаж, шалгарсан аж, ахуйн нэгж, байгууллага, компаниудтай нийт 614 гэрээ байгуулсан байна. Энэ гэрээг байгуулахдаа гэрээний ерөнхий нөхцөлийн 1.9-д Авлигал болон залилан мэхлэх үйлдэл: "Захиалагчийн төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон төндөрт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч</p>	100 хувь

	урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах.		зөвлөх бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин Биелүүлэх ёстой" гэсэн заалтыг тусгаж өгч, гэрээг байгуулан үр дүнтэй ажиллаж байна.	
4.3. Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал үзүүлэх, санаачилга өрнүүлэх.			Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал үзүүлэх, санаачилга өрнүүлэх болон албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор БХБД нь 78 орон тоотой байхаас хүний нөөцийн нөхөн хангалт нь 77 ажиллах хүчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Төрийн албан хаагчийн нөхөн хангалт 99%-тай байна. Хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагч байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар томилсон 24 түр чөлөөлсөн, чөлөөлсөн 25, шилжин сэлгэн ажилласан 5, түр орлон гүйцэтгүүлсэн 5, хүүхэд асрах чөлөө сунгасан 1, сургалт болон эрүүл мэндийн асуудлаар чөлөө олгосон 12, сахилгын шийтгэл хүлээлгэсэн 2, зэрэг дэв олгосон 2, ажилласан жилийн нэмэгдэл урамшуулал олгосон 3 нийт хүний нөөцийн ажиллах хүчинтэй холбоотой тушаал 79 батлагдаж хэрэгжилтийг хангуулсан байна. Албан хаагчдын зүгээс тушаал шийдвэртэй холбоотой санал гомдол ирээгүй. "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг 8 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 75 дугаар тогтоолоор яамны албан хаагчдын цалинг 42 хувиар нэмэгдүүлсний дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Б/05, 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Б/30-р тушаалаар албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон. Үүнтэй холбогдуулан шинээр ажилд орж байгаа болон шатлан дэвшсэн албан хаагчдын цалинг тухай бүр тооцож олгож байгаа болно. Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2 дугаар хуралдаанаар Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг яамны 4 албан хаагчдад зэрэг дэв ахиулан, 1 албан хаагчид шинээр, агентлагын 14 албан хаагчдад ахиулан, 1 албан хаагчид шинээр тус тус олгуулахаар салбар зөвлөлийн 4 дүгээр тогтоол хэрэгжсэн байна. Барилга хот байгуулалтын сайдын 2022.03.24-ны өдрийн 66 дугаар "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" тушаалын хэвсрэлтээр дээрхи албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдэл олгогдож хэрэгжилт хангагдсан байна. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн тушаалын зэрэг дэв олгох тухай" 53 дугаар захирамжийг үндэслэн ТНБД-ын Б/29 дүгээр тушаалаар эрхэлсэн 3 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон. Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2022.11.01-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар шаардлага	100 хувь

хангасан 3 албан хаагчдын мэдээллийг 2022.11.02-ны өдрийн 1/5069 дүгээр албан тоотгоор Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн нарийн бичгийн 2022.05.25-ны өдрийн Б/47 дугаар тушаалаар Албан хаагчдын 2022 оны ээлжийн амралтын хуваарь батлагдаж, хэрэгжилт хангагдаад байна. Тушаалыг байгууллагын <https://epr.e-mongolia.mn/> цахим системд нээлттэйгээр байршуулсан.

2022 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор яам, агентлагийн 145 албан хаагчдыг богино хугацааны сургалтуудад, 5 албан хаагчдыг БНСУ-ын их дээд сургуульд магистрын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулсан. Тухайлбал: Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2, ахлах түшмэлийн багц сургалтад 7, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх датван сургалтад 6 албан хаагчид, Монгол Улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ "алсын хараа -2050" сургалтад 76, "Их өгөгдөлийг бодлогын шийдвэрт ашиглах нь" сургалтад 1, 2022.4.11-15-нд "Үндэсний тэнцвэртэй хөгжлийн төлөөх бүс нутгийн бодлого, төлөвлөлт" сургалтад тус яам, харьяа байгууллагуудаас 20, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал" сэдэвт сургалтад 35 албан хаагчдыг тус тус хамруулах ажлыг зохион байгуулсан.

КОЙКА-тай хамтран "Үндэсний тэнцвэртэй хөгжлийн төлөөх бүс нутгийн бодлого, төлөвлөлт" сургалтад БНСУ-д 28 албан хаагчдыг богино хугацаанд хамруулсан.

БНСУ-ын КОЙКА-ын шугамаар тус улсын Инcheon-ы их сургуулийн Төрийн удирдлагад 1, хот ба бүсийн нутгийн төлөвлөлтийн магистрын сургалтад 2, тус улсын Их дээд сургуульд 2 албан хаагчдийг нэр дэвшүүлэн материалуудыг нь Сангийн яам, ГХЯ-нд тус тус хүргүүлж, шийдвэрлүүлсэн. НҮБ болон ТАЭ-тай хамтран Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд "Стратегийн баримжаатай хүний нөөц", "Ес зүйн зөвлөлийг чадавхжуулах" дэд төслийн нээлтийг Төрийн албаны зөвлөлөөс 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр хийж, уг арга хэмжээгээр Төрийн албан хаагчийн зарчимч, шударга байдлыг бэхжүүлэх дэд төслийн эхний ээлжинд хэрэгжүүлэхээр Барилга, хот байгуулалтын яам сонгогдсон. Төслийн төлөвлөгөөнд Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Мангайсүрэн нар гарын үсэг зурж баталгаажуулсан.

Стратегийн баримжаатай хүний нөөцийн хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн:

1.Дэд төслийн хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны удирдах болон гүйцэтгэх албан хаагчдад 2022.05.10-ны өдөр төслийн танилцуулгыг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, НҮБ-ын менежер, зөвлөхүүд ирж мэдээлэл хийсэн.

2.2022.05.26-ны 10 цагт НҮБ-ын 4 зөвлөх хүрэлцэн ирж "Үр дүнд суурилсан албан тушаалын тодорхойлолт боловсруулах, Чадамжид суурилсан ярилцлага хийх" сэдэвт сургалтыг хийж, Төрийн албаны

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн 9, болон сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт оролцдог 5 албан хаагчдыг мэдлэг мэдээллээр хангасан.

3.2022.12.06-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын инженерийн дэд бүтцийн хэлтсийн Дулаан, ус хангамжийн дэд бүтцийн бодлого, зохицуулалт хариуцсан шинжээч, Бодлого, төлөвлөлтийн газрын Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн Ипотек, түрээсийн тогтолцоо хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад Чадамжид суурилсан ярилцлагад НҮБ-ийн зөвлөх багийг ажиглагаар оролцуулахаар төлөвлөсөн.

Ёс зүйн зөвлөлийг чадархижуулах хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд:

Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, 21 аймаг, нийслэлийн Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газарт нийт 944 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 23 Ёс зүйн салбар зөвлөлүүдэд 110 албан хаагчид ажиллаж байна. Эдгээр албан хаагчдын төрийн албанд ажилласан жил дунджаар 13.4 байна. Ёс зүйн зөвлөлийн албан хаагчид байгуулагдаа, салбарт ёс зүйн зөв хандлага, хариуцлага, төлөвшлөөр сургах, манлайлах, нөлөөлөх, албан хаагчдыг авилга, албан тушаалаа урвуулан ашиглах, ёс зүйн зөрчлөөс ангидаг байх, урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн удирдлагыг төлөвшүүлэх зэрэг чиглэлээр тодорхой сургалт, арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.

Дэд төслийн хүрээнд хийгдэх ажлуудаа БХБЯ-ны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн 2022 оны үйл ажиллагаа, сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулж байна. Тухайлбал:

1. Албан хаагчдын ёс зүйн чадамжийг дээшлүүлэх хүрээнд яамны гүйцэтгэх түвшний албан хаагчдад 2022 оны 5 дугаар сарын 23, 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд "Албан хаагчийн шударга, зарчимч байдлыг нэмэгдүүлэх нь" сэдэвт:

2. БХБЯ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн удирдах шатны албан хаагчдад зориулсан "Удирдах албан хаагчийн ёс зүйн манлайлаг" сургалт-хэлэлцүүлгийг 9 дүгээр сарын 6-нд тус тус зохион байгуулсан. Сургалт-хэлэлцүүлэгт 152 албан хаагчдыг хамруулсан.

3. ГЗБГЗЗГ-ын албан хаагчдын ёс зүйн чадамжийг бэхжүүлэх сургалтыг 9 дүгээр сарын 23-ний өдөр зохион байгуулж, нийт 56 албан хаагч хамрагдсан. Архангай аймгийн ГХБХБГ-ын албан хаагч, сумдын газрын даамлууд нийт 40 албан албан хаагчдыг тус тус хамруулсан. Эдгээр сургалтууд нь яам, харьяа байгууллагын албан хаагчдад аливаа зөрчлөөс ангидаг байх мэдлэг, ойлголтыг өгсөн ба 2021 онд ёс зүйн зөрчлийн томдол, санал илрээгүй.

4. Яамны албан хаагчид хоорондын найрсаг харилцаа, хандлагыг хөгжүүлж, сэтгэл ханамж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилго

			<p>Бүхий "Талархлын аян"-ыг зохион байгуулсан. Энэ үеэр 200 гаруй талархал илэрхийлсэн зурвасуудаар бие биедээ урам өгч, сайхан сэтгэгдэлийг төрүүлжээ. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ёс зүй зөвлөлийн ажиглах журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиглаж байна.</p> <p>5. "Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр"-г яам, харьяа байгууллагуудын 12 эмэгтэй албан хаагчдыг хамруулсан.</p> <p>6. Даманд шинээр ажигдг орсон төрийн албан хаагчийн хөгжлийн суурийг тавих, чадавхийг төлөвшүүлэх, дадлага туршлага хуваалцах, чиглүүлэх зөвлөх зорилгоор Менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт 18 албан хаагчид оролцсон ба дараах үр дүнгүүд гарч байна. Үнд:</p> <p>- Албан хаагчид, албан тушаалтнууд зарим нь зөвхөн нэрс, албан тушаалаа мэддэг байсан бол илүү танилцах;</p> <p>- Хамт олны уур амьсгал, хүмүүс хоорондын харилцаа сайжрах;</p> <p>- Мэдлэг, туршлага хуваалцах, өвлөх, дамжуулах, түгээх;</p> <p>- Ёс зүйн чадамжийг нь дээшлүүлэх;</p> <p>- Стресс бууруулах;</p> <p>- Ажлын ачаалал хуваалцах зэрэг болно.</p> <p>7. Газрын салбарын удирдах ажилтны 2022 оны 02 сарын 14-ний өдрийн зөвлөгөөнд 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны удирдах ажилтнуудад, Төв аймгийн ГХБХБГ-аас 2022 оны 03 сарын 09-11-ний өдөр зохион байгуулсан сумын Газрын даамилуудад зориулсан сургалтад "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр байгууллагын Ёс зүйн зөвлөлийн дарга Л.Дувсан илтгэл тавьсан.</p> <p>8. Мөн Өмнөговь аймгийн ГХБХБГ-аас 2022 оны 03 сарын 11-ний өдөр зохион байгуулсан сумын Газрын даамилуудад зориулсан сургалтад Ёс зүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Мөнхзүл "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр цахимаар илтгэл тавьж оролцсон.</p> <p>9. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн 2022 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдын дунд төрийн албан хаагчид болон бусад ажилтнуудын ёс зүйн талаарх ойлголт, мэдлэгийн талаар, мөн байгууллагын албан хаагчдад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлох зорилгоор судалгаа хийсэн. Судалгаанд нийтдээ 1 сараас 30 жил ажилласан 52 албан хаагч оролцсон байна. Судалгааны дүнг нэгтгэн удирдлагад танилцуулав</p> <p>10. Тус Ёс зүйн зөвлөлөөс 2022 онд төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон 3 албан хаагчдад туршилтын хугацаанд ажиглах хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан эсэх дүгнэлт гаргах ажлыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>11. "Газрын харилцааны салбарын ёс зүйн дүрэм"-ийг шинээр, "Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн ажиглах журам"-ыг шинэчлэн боловсруулж, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот</p>
--	--	--	---

				<p>шинжээч С. Оюунжаргал, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Б.Цолмон нар хамрагдсан.</p> <p>Мөн төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчдад зориулсан 4 дэх өдөр бүр зохион байгуулагдаж буй 7:4:10 25 сургалтад яам болон агентлагын давхардсан тоогоор 1575 албан хаагчийг хамруулж яам болон харьяа байгууллагын цахим хуудсанд нийтэлж, нийслэл, аймаг, орон нутгийн нийт төрийн албан хаагч, олон нийтэд түгээн сурталчилж ажигласан.</p>
5. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах	5.1.Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний талаар (И-Монголиад холбосон, автоматжуулсан үйлчилгээг оруулна) мэдээлэл.			<p>Газар, хот байгуулалт, газрын харилцаатай холбоотой тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрх олготой холбоотой үйл ажиллагааг 100 хувь цахим системд шилжүүлсэн /www.tcis.gov.mn, www.license.gazag.gov.mn/. Дээрх мэдээллийн сангууд нь нийтийн мэдээллийн дэд бүтцийн үндсэн систем /ХУР/, дэмжих систем /ДАН/-үүдтэй холбогдон ажилладаг.</p> <p>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia"-д дараах 5 тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээг холбосон. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл; 2.Барилгын ажиг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл; 3.Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт засвар үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл; 4.Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл; 5.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах мэргэжлийн эрх. <p>Холбоос: https://e-mongolia.mn/licenses/legal-entity/sector/5d88ddc70384dfe86ce14e74</p> <p>2022 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн мэдээллийн системээр дамжуулан нийт 4742 хүсэлтийг хүлээн авч, 1214 ААНБ тусгай зөвшөөрөл олгосон ба үүнээс зураг төслийн 291, барилга угсралтын 868, өргөх байгууламжийн 33, барилгын материал үйлдвэрлэлийн 21, хот байгуулалтын баримт бичгийн 1 ААНБ-д тусгай зөвшөөрөл олгосон байна. Цахим системээр олгосон тусгай зөвшөөрлийн 98.2 хувийг Монголын Барилгын Үндэсний ассоциаци, 1.8 хувийг Монголын Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбоо, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар хянаж, олгох ажлыг зохион байгуулан ажилласан байна.</p> <p>Газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын хяналтын үнэлгээний мониторингийн сүлжээ, газрын биржийн болон газрын үнэлгээ, төлбөр, татвар, хураамж, газрын кадастрын бүртгэлийн цахим систем бүхий газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем /www.e-gazag.gov.mn/-ийг хөгжүүлж, Засгийн газрын 2020.03.25-ны өдрийн 110 дугаар тогтоолоор улсын хэмжээнд нэвтрүүлсэн ба 2022 оны 12 дугаар сарын байдлаар газрын харилцаатай холбоотой иргэнд чиглэсэн 42, аж ахуйн нэгж</p>
12				100 хувь

				<p>Байгууллагад чиглэсэн 30 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байгаа бөгөөд үүнээс 45 үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д холбосон. Уг системд өдөрт дунджаар 14,000 гаруй, сард 435,000 иргэн, хуулийн этгээд ханддаг ба авч буй үйлчилгээний 52 хувийг газрын албанд хүсэлт илгээх, 25 хувийг газартай холбоотой үйлчилгээ авах, 20 хувийг лавлагаа авах, 3 хувийг газрын татвар, төлбөр төлөхтэй холбоотой үйлчилгээ эзэлж байна. Салбарын шангалд нэр дэвшигчийн хүсэлтийг цахимаар хүлээн авах eward.mcsud.gov.mn-ийг тус нам хөгжүүлж, уг системээр дамжуулах салбарын шангалтай үйл ажиллагааг 100 хувь цахимаар шийдвэрлэж байна. 2022 онд уг системээр дамжуулан 2000 гаруй салбарын шангалд нэр дэвшигчийн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн.</p>	
13	<p>5.2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилган сэргийлэх хүрээнд төрийн үйлчилгээний зохион байгуулалтыг өөрчилсөн, стандартыг шинэчилсэн талаар мэдээлэл.</p>			<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор барилгын салбарын цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулган хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Уг төлөвлөгөө нь БХБЯ түүний харьяа 4 байгууллагын 19 зорилтын 71 арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2022 оны I улирлын байдлаар дараах мэдээллийн системүүдийг 100 хувь хэрэглээнд нэвтрүүлж, төрийн үйл үйлчилгээг цахимаар үзүүлж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Барилгын мэдээллийн нэгдсэн систем www.mcis.gov.mn/; 2.Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем www.egeazar.gov.mn/; 3.Газрын Биржийн цахим систем www.mle.mn/ 4.Газрын кадастрын нэгдсэн систем www.egeazar.gov.mn/; 5.Газрын үнэлгээ, татвар, төлбөрийн цахим систем www.egeazar.gov.mn/; 6.Хаягийн мэдээллийн нэгдсэн систем; 7.Газрын мониторингийн цахим систем www.egeazar.gov.mn/; 8.Орон зайн суурь 16 төрлийн өгөгдөл солилцох "нэг газрын зураг, нээлттэй газрын зураг" үйлчилгээ www.npsdi.gov.mn/; 9.Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн мэдээллийн систем license.mcis.gov.mn/; 10.Газрын харилцааны салбарын тусгай зөвшөөрлийн болон мэргэжлийн байгууллагын эрх олгох цахим үйлчилгээ license.gazag.gov.mn/; 11.Газрын харилцааны салбарын төрийн болон байгууллагын архивын баримтын цахимжуулалт; 12.Геодези, зураг зүйн бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, цахим үйлчилгээ geosocal.gazag.gov.mn, topros.gazag.gov.mn, point.gazag.gov.mn/; 13.Барилгын салбарын зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн систем www.mcis.gov.mn/; 14.Ундны усны чанарын нэгдсэн мэдээллийн сан water.wsgc.mn/; 	100 хувь

					<p>Дээрх системүүд хэрэглэнд нэвтэрснээр газрын харилцаатай холбоотой төрөл бүрийн лавлагаа, кадастрын зураг, хянан баталгааны дүгнэлт, газар эзэмших гэрээ, гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаар авах үйлчилгээг дунджаар 20-40 хоног зарцуулж авдаг байсан бол 1-10 минутанд орон зай, цаг хугацаанаас үл хамрааран авдаг болсон. Мөн тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээг 30-45 хоног зарцуулж авдаг байсан бол одоо 10 хоногт багтаан авдаг болсон.</p>	
	<p>5.3.Хүнд суртал, чирэгдлийг бууруулах, шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор өөрчлөлт оруулсан дүрэм, журмын талаар мэдээлэл</p>				<p>Хүнд суртал, чирэгдлийг бууруулах, шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор шинэчлэн баталсан болон өөрчлөлт оруулсан дүрэм, журмын хүрээнд дараах дүрэм журмыг батлуулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдүүдэд цахимаар үйлчилгээ үзүүлдэг болсон. Үүнд:</p> <p>“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм батлах тухай” Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол; “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм батлах тухай” Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 213 дугаар тогтоол;</p> <p>“Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага бүртгэх журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 343 дугаар тогтоол;</p> <p>“Журам батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 139 дүгээр тушаал /барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах/</p> <p>-Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 230 дугаар тушаалаар барилга, хот байгуулалтын салбарын батлагдсан хэм хэмжээний актуудыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх зорилгоор 23 тушаалын үндэслэл хэсэгт өөрчлөлт оруулж, мөн түүнчлэн эрх зүйн үйлчлэлийг, сонгон мөрдөх захиргааны актад хамаарах болсон 4 тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцож, улмаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр бүртгүүлсэн. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2021 оны 62 дугаар тэмдэглэлийг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас үлдсэн захиргааны хэм хэмжээний актуудад хяналт-шинжилгээ хийж, нягтлан шалгаж тэдгээрийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэхийг чиглэл болгож албан бичиг ирүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу барилгын салбарт мөрдөж байгаа захиргааны хэм хэмжээний актуудад дахин судалгаа хийн шүүж Барилгын тухай хууль батлагдсантай холбоотой эрх олгосон хуулийн заалт өөрчлөгдсөн нийт 52 тушаалд намалт, өөрчлөлт оруулан танилцуулга, нөлөөллийн шинжилгээг тус тус хийсэн бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын 3 дугаар сарын 4-ний өдрийн 57 дугаар тушаалаар баталсан. Мөн уг тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.</p>	<p>100 хувь</p>
14						

	<p>5.4. Авлигын эрсдэлийн үнэлгээ, үйл ажиллагаанд мониторинг, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан эсэх талаар мэдээлэл.</p>					<p>2022.03.09-ний өдрийн "Монгол наадам үндэсний спорт цоллолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай" 99 дүгээр тогтоол, 2022.10.19-ний өдрийн "Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын зориулалтаар 20 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" 377 дугаар тогтоол</p> <p>2.Барилга, хот байгуулалтын сайдын 2022.09.19-ний өдрийн "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөгт" /БНБД 31-24-22/ норм, нормативын баримт бичиг батлах тухай 193-р тушаал,</p> <p>2022.10.19-ний өдрийн "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөгт" /БНБД 31-25-22/ барилгын норм, дүрмийг батлах тухай" 211 дүгээр тушаал.</p> <p>Авлигатай тэмцэх газраас сонгон шалгаруулсан хөндлөнгийн хараат бус судалгааны байгууллагаар байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийлгэж, Шударга байдлын үнэлгээг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д "төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх" гэж заасны дагуу 2 жил тутам /2020-2021/ Авлигатай тэмцэх газраас хийдэг бөгөөд өмнөх жилд Барилга, хот байгуулалтын яам авлигын эсрэг шударга байдлын үнэлгээгээр 73 хувьтай үнэлэгдсэн байна. Авлигатай тэмцэх газрын захиалгаар "SICA" компаниас "Шударга байдлын үнэлгээ-2022"-г 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгууллагын нийт 50 албан хаагчдаас авах ажиллагааг амжилттай зохион байгуулж ажилласан. Мөн төрийн захиргааны төв байгууллага /Барилга, хот байгуулалтын яам/-аар үйлчлүүлдэг иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл болох нийт 30 байгууллагаас "Шударга байдлын үнэлгээ-2022 судалгааг авах бөгөөд тус компаниас уг үйл ажиллагааг "Барилгын үндэсний ассоциаци" Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж байгаа болно. АТГ-аас "Монголын Барилгын инженер холбоо" ТББ-тай хамтран барилгын салбарыг авлигаас ангид байлгах, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд инженерүүдийн ёс зүйг бэхжүүлэх, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай, ил тод, хүнд суртал чирэгдэлгүй хүргэх чиглэлээр "Барилгын салбар дахь авлигын эрсдэл ба инженерийн ёс зүй" сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Матнайсүрэн, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга, Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж нар тус тус оролцож, барилгын тусгай зөвшөөрөл олгох үйл явцын хяналтыг сайжруулах, ил тод болгох, хүнд суртал чирэгдлийг багасгах, барилга эхлэхээс дуусах хүртэл үйл явцын чанарын асуудал, хяналтын тогтолцоог сайжруулах, чанарын шаардлага хангаагүй</p>
15						

					<p>Барилгыг хүлээн авахгүй байх, мөн түүнчлэн зураг төсөл, магадлал хийгдээгүй, тендер сонгон шалгаруулалтгүй, улсын төсвийн төсөлд зураг төсөлгүй ажлуудыг оруулж төсөв баталдаг болон холбогдох бусад асуудлуудыг хөндөж, амжилттай зохион байгуулсан. Энэ хэлэлцүүлгээр хөндсөн асуудлаар АТГ-аас "Зөвлөмж хургуулэх тухай" 2022 оны 12.06-ны өдрийн 01/16409 дугаар албан бичгээр Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу тус яаманд зөвлөмж ирүүлсэн бөгөөд уг зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг шат дараатай авахаар ажиглаж байна. "Авлигын эсрэг олон улсын өдөр" 2022 оны 12 дугаар сарын 09-ний тохиож байгаатай холбогдуулан АТГ-аас холбогдох төрийн байгууллагуудын хүрээнд арга хэмжээ зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Мангайсүрэн болон холбогдох газар, хэлтсийн дарга нар тус тус оролцож, барилгын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудлууд, барилгын салбарын цахимжилт, эрх зүйн шинэчлэлүүд мөн түүнчлэн барилгын салбарт хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд салбарын байр суурь, чиглэл зорилтын талаар РРТ танилцуулга, мэдээллийг өгч, амжилттай оролцсон. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт болон Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны тайлан, хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр Барилга, хот байгуулалтын яам 84.7 хувьтай үнэлэгдсэн байна.</p>	
16	<p>6.1. Төрийн байгууллагын вэб сайтэд тавих шаардлагад нийцүүлэн албан ёсны цахим хуудсыг хөгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэх.</p>				<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэн тэй холбогдуулан Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/168 дугаар тушаалаар "Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим хуудсыг хөтлөх журам", Нээлттэй мэдээллийг бэлтгэж, цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, түүнд хяналт тавих чиг үүргийн хуваарийг тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиглаж байна. Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудасны хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавьж, цаг үеийн шинж чанартай үйл явдлын мэдээ, тендерийн урилга, шинэ ажлын байрны сонгон шалгаруулалтын зар зэрэг мэдээ мэдээллийг тухай бүр цахим хуудсанд нийтлэн ажиглаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, цахим хуудсанд шинээр албан тушаалын тодорхойлолтыг байршуулж, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг гэсэн шаардлагатай мэдээллийг шинэчлэн нийтэлжээ. Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудас (www.mcsud.gov.mn)-ны нүүр хэсгийн тусгай зөвшөөрөл цэсэд</p>	100 хувь

				<p>салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийг Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталгаар дамжуулан хүлээн авах боломжийг бүрдүүлж, ойлгомжтой байдлаар байрлуулсан, Монгол Улсын Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газраас гаргасан харьяа яамдын цахим хуудсанд анхаарах зөвлөмжийн дагуу Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудас (www.mcsid.gov.mn)-ны үндсэн цэсэнд Төрийн үйлчилгээ (Emongolia), Өргөдөл гомдол шийдвэрлэх (11-11.mn), Стандарт, хэмжил зүйн газар (standards.gov.mn)-ын тус тус байршуулсан, Барилгын салбарын шатналд нэр дэвшилчийг цахимаар бүртгэх систем, Барилгын салбарын алдар цолтны бүртгэлийн системийг хөгжүүлж, алдар цолтон болон ахмадуудын мэдээллийг gesawd.mcsid.gov.mn сабдомайны хаяг дээр байрлуулж, хэрэглээнд нэвтрүүлээд байна.</p>	
17	<p>6.2. Шилэн Дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-т заасан заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиглах.</p>			<p>Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэл стандартыг тогтоох журмын дагуу календарчилсан төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээллийн тайланг улирал бүр гаргуулан авч Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэл стандартыг тогтоох журам"-ын 8.2 дахь хэсэгт заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2020 оны 4 дүгээр улирлын тайланг 2021.01.22-ны өдрийн 10/325 тоот, 2021 оны 1 дүгээр улирлын тайланг 2021.04.20-ны өдрийн 05/1434 тоот албан бичгээр Сангийн яамны Төсвийн хяналт эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/2684 дугаартай албан бичгээр Монгол Улсын Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд"-ын дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 2.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 245 төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн, үнэлгээ хийж холбогдох жагсаалтыг Сангийн яаманд хүргүүлсэнээс гадна цахим системээр хугацаанд нь илгээсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 1/3787 дугаартай албан бичгээр Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд"-ын дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг нэгтгэн, боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн цахим системээр төсвийн төсөл болон төлөвлөлттэй холбогдох материалыг хугацаанд нь илгээсэн. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны төсвийн төслийн талаарх мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулж,</p>	100 хувь

						<p>Мөн яамны санхүү, төрийн сангийн үйл ажиллагааны хүрээнд нийт 236 мэдээллийг 2022 оны Шилэн дансанд байршуулж ажилласан болно. Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу календарчилсан төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээллийн тайланг улирал бүр гаргуулан авч Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8.2 дахь хэсэгт заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2022 оны 03 дугаар улирлын тайланг 2022.10.14-ний өдрийн 10/4738 тоот албан бичгээр Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1/3248 дугаартай албан бичгээр Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд"-ын дагуу БХБ-ын сайдын багцын 2023 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг нэгтгэн, боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэнээс гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим программд холбогдох мэдээлэл болон шаардлагатай баримт, материалуудыг хугацаанд нь оруулан илгээсэн. Мөн БХБ-ын сайдын 2022 оны төсвийн зарцуулалт, 2023 оны төсвийн төслийн талаарх мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд нь байршуулан ажилласан.</p>	
--	--	--	--	--	--	---	--

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН